

**СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ
Аудитын код: САГ-2018/131/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885
Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Д.Цэгмиддорж
Утас: 261740
Цахим хаяг: tsegmiddorj@audit.gov.mn

Ай Жэй Эй Эйч аудит ХХК-ийн захирал Г.Энхмаа
Утас: 99040059 450279
Цахим хаяг: Enkhmaa_56@yahoo.com

Чанарын хяналтын мэргэжилтэн Л.Оюунцэцэг
Утас: 99073014
Цахим хаяг: oyuntsetsegl@yahoo.com

Аудитор Н.Уранчимэг
Утас: 91093898
Цахим хаяг: urnaа_mhg@yahoo.com

Улаанбаатар хот



Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар	4
2.9.2	Албан томилолтын зардлын талаар.....	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	4
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	4
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	4
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	5
3	Менежментийн захидал	6
3.1	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар.....	7
3.2	Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар.....	8
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	9
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА

2018.02.23 № 06/469
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Соёлын өвийн үндэсний төв"-ийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



020502

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1—д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2 Аудитын тайлан

2.1 Оршил

Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Соёлын өвийн үндэсний төвийн захирал төсвийн шууд захирагч Г.Энхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах аргыг өөрийн байгууллагын онцлогт тохируулан тогтоох зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Соёлын өвийн үндэсний төв”-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 29-нөөс 2018 оны 2 дугаар сарын 22-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 2 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ай Жэй Эй Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Энхмаа хариуцаж хэрэгжүүлэв.



Аудитаар Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 38 тоот албан бичгээр Ай Жэй Эй Аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Соёлын өвийн үндэсний төв санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалтыг үндэслэн Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын 2017 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар Соёлын өвийн үндэсний төвийн бүтцийг 28 орон тоотойгоор баталсан байна.

Соёлын өвийн үндэсний төвийн эрхэм зорилго нь :

Монгол үндэстний соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, бүртгэн баримтжуулах сэргээн засварлах хойч үедээ өвлүүлэн уламжлуулахад эрхэм зорилготой

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Соёлын биет өв болох түүх, соёлын хөдлөх дурсгалыг хамгаалах
Соёлын биет өв болох түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах
Соёлын биет бус өвийг хамгаалах
Музейн үзмэр, түүх, соёлын хөдлөх дурсгалыг сэргээн засварлах, бэхжүүлэх
Эртний дурсгалт хөшөө чулуу, хадны сүг зураг, бичээс зэрэг байгаль дээр ид задгай орших түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг сэргээн засварлах, бэхжүүлэх

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Музейн үзмэрийг бүртгэн баримтжуулах, Соёлын өвийн бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэхэд заавар зөвлөгөө, аргачлал өгөх, арга зүйгээр хангаж ажиллах,
Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалын жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн батлуулах,
Түүх, соёлын хөдлөх дурсгалыг баримтат кино, дуу, дүрс бичлэг, хэвлэмэл болон электрон хэлбэрээр нийтэд сурталчлах,
Музейн үзмэр, түүх, соёлын хөдлөх дурсгалын тооллого, зэрэглэл, үнэ үнэлгээ, даатгал тогтоох асуудлаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах
Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Соёлын өвийн үндэсний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Соёлын өвийн үндэсний төв нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “aculous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Соёлын өвийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай гэж үзлээ.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн шууд захирагчийн 2017 оны төсвийн урсгал зардалд 414,520.1 мянган төгрөгийн төсөв батлагдснаас гүйцэтгэл 413,433.9 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан. Төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хураангуй

/ мянган төгрөгөөр/				
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Зөрүү				
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	414,520.1	413,433.9	99,7
1,086.2				
1.1	Урсгал зардал	414,520.1	413,433.9	99,7
1,086.2				
1.2	Хөрөнгийн зардал			
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл			
2	Зардал санхүүжүүлэх эх үүсвэр	414,520.1	413,433.9	99,7
1,086.2				
2.1	Улсын төсвөөс санхүүжих	414,520.1	413,433.9	99,7
1,086.2				
2.2	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжих			

2.7 Шилэн дансны мэдээлэл

Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар нь Шилэн дансны хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулж байна. Байгууллагын цахим хуудас www.monheritage.mn сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цагийнхаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг оруулсан. 2017 оны төсөв гүйцэтгэлд 9 мэдээлэл оруулахаас жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтээс бусдыг хугацаанд нь, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтыг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу 6 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

Тус байгууллага нь Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолоор баталсан журамд заасан хугацааг баримталсан нь 2014 оны 9 дүгээр сарын 18 ны өдрийн 297 тоот тогтоолоор хүчингүй болсон байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ шинээр мөрдөж байгаа зарим стандарт хууль эрхийн зарим актын өөрчлөлтийг тусгаж шинэчлэх шаардлагатай байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар үндсэн хөрөнгийн элэгдлийг өөрийн байгууллагын онцлогт тохируулан байгуулахаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ шинээр мөрдөж байгаа стандарт, эрх зүйн орчинтой нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах зөвлөмж өгөх

2.9.2 Албан томилолтын зардлын талаар

Тус байгууллага албан томилолтын зардлыг урьдчилан олгодог байна. Урьдчилгааг дараа тайлангийн тооцоонд бичиж томилолтоор ажиллаад ирсний дараа урьдчилгаа тооцоог хааж хэвшээгүй байна. Томилолтын бодолтыг хийхдээ үнэмлэх дээрх ажилласан өдөр хоногийг илүү тооцож олгосон ба жилийн дүнгээр 354.0 мянган төгрөг болсон байгаа нь Засгийн Газрын 1995 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт д заасан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" ын 9, 12 дахь заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Албан томилолтын хугацааг зөв тооцож олгох талаар байгууллагын дарга эрхлэгч нарт зөвлөмж өгөх

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Соёлын өвийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар нэмэлт санхүүжилтийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛҮЙН НЭГТГЭЛ

Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 354,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 354,0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичиж, 1 зөвлөмж өгсөн.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Соёлын өвийн үндэсний төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

САГ-2018-/131/СТА-ТШЗ

Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 638,935.7 мянган төгрөг бөгөөд 2 хувиар буюу 12,778.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь өмнөх аудитуудаар зөрчилгүй санал дүгнэлт авч байсан, санхүү бүртгэлийн ажилтнууд харьцангуй тогтвор суурьшилтай ажиллаж байгаа тул эрсдэл бага гэж үнэлсэнтэй холбоотой юм.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Соёлын өвийн үндэсний төвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Соёлын өвийн үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо Засгийн газрын 233-р тогтоолоор баталсан журамд заасан хугацааг баримталсан байна. Энэ тогтоол 2015 онд хүчингүй болсон боловч Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичигт өөрчлөлт оруулаагүй байна.

Эрсдэлүүд

Үнэн зөв байдал- Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх батламж мэдэгдэл зөрчигдөх.

ҮАГ-ын зөвлөмж

Үндсэн хөрөнгийн элэгдлийг өөрийн байгууллагын онцлогт тохируулан байгуулахаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ шинээр мөрдөж байгаа стандарт, эрх зүйн орчинтой нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 30 ны дотор Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 Үндсэн хөрөнгийн элэгдлийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага албан томилолтын зардлыг урьдчилан олгодог байна. Урьдчилгааг дараа тайлангийн тооцоонд бичиж томилолтоор ажиллаад ирсний дараа урьдчилгаа тооцоог хааж хэвшээгүй байна. Томилолтын бодолтыг хийхдээ үнэмлэх дээрх ажилласан өдөр хоногийг илүү тооцож олгосон ба жилийн дүнгээр 354.0 мянган төгрөг болсон байгаа нь Засгийн Газрын 1995 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт д заасан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" ын 9, 12 дахь заалтыг зөрчсөн.

ҮАГ-ын зөвлөмж

Албан томилолтын хугацааг календарийн хоногоор зөв тооцон, олгож, хэвших, холбогдох заавар журмыг мөрдөж ажиллах
Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 06 дугаар сарын 30 ны дотор Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар ирүүлэх

Эрсдэлүүд

Үнэн зөв байдал- Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх батламж мэдэгдэл зөрчигдөх.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/		
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,253,527.58	126,007,547.28
АВЛАГА	9,079,500.00	-
Бусад авлага	9,079,500.00	-
Байгууллагаас авах авлага	9,079,500.00	
БАРАА МАТЕРИАЛ	63,174,027.58	126,007,547.28
Хангамжийн материал	63,174,027.58	126,007,547.28
Бичиг хэргийн материал	670,600.00	639,000.00
Аж ахуйн материал	171,580.00	186,430.00
Сэлбэг хэрэгсэл	100,000.00	320,000.00
Барилгын засварын материал	4,592,600.00	5,362,500.00
Түлш шатах тослох материал		60,000.00
Бусад хангамжийн материал	57,639,247.58	119,439,617.28
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	584,955,411.45	738,195,376.01
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	584,955,411.45	738,195,376.01
Биет хөрөнгө	565,663,744.50	719,920,375.42
Барилга байгууламж, орон сууц	16,900,000.00	10,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(8,810,000.06)	(4,600,000.100)
Авто-тээврийн хэрэгсэл	282,000,000.00	282,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(164,986,111.36)	(197,819,444.80)
Машин тоног төхөөрөмж	1,387,170,819.14	1,464,081,744.48
Хуримтлагдсан элэгдэл	(958,332,206.03)	(1,051,018,597.81)
Тавилга, эд хогшил	57,425,786.03	263,776,292.03
Хуримтлагдсан элэгдэл	(49,314,914.22)	(50,474,989.38)
Номын фонд	3,610,371.00	3,975,371.00
Биет бус хөрөнгө	19,291,666.95	18,275,000.59
Програм хангамж	64,570,000.00	74,170,000.00
Хасагдуулга	45,278,333.05	55,894,999.41
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	657,208,939.03	864,202,923.29
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	7,875,000.00	
Богино хугацаат өр төлбөр	7,875,000.00	
Өглөг	7,875,000.00	
Хувь хүмүүст төлөх өглөг	7,875,000.00	
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	649,333,939.03	864,202,923.29
Засгийн газрын хувь оролцоо	693,094,306.63	693,094,306.63
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	693,094,306.63	693,094,306.63
Өмч: - төрийн	693,094,306.63	693,094,306.63
Хуримтлагдсан үр дүн	(43,760,367.60)	171,108,616.66
Өмнөх үеийн үр дүн	(43,760,367.60)	(43,760,367.60)
Тайлант үеийн үр дүн		214,868,984.26
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	657,208,939.03	864,202,923.29

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	628,475,941.40	863,023,484.75
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	329,363,389.75
Нийтлэг татварын бус орлого	-	329,363,389.75
Төсөвт байгууллагын өөрийн орлого		
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		329,363,389.75
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	628,475,941.40	533,660,095.00
Улсын төвлөрсөн төсвөөс	369,555,884.00	414,020,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	369,555,884.00	414,020,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	258,920,057.40	119,639,995.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	214,705,238.00	111,589,995.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,228,600.00	8,050,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,986,219.40	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	794,990,031.71	648,154,500.49
УРСГАЛ ЗАРДАЛ	794,990,031.71	648,154,500.49
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	784,943,897.21	638,935,653.19
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	380,500,537.00	315,205,068.00
Үндсэн цалин	352,276,537.00	287,263,268.00
Унаа хоолны хөнгөлөлт	28,224,000.00	27,941,800.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,401,084.00	36,219,431.00
Тэтгэврийн даатгал	27,295,471.00	23,311,396.00
Тэтгэмжийн даатгал	3,076,127.00	3,262,300.00
ҮОМШӨ-ний даатгал	3,845,158.00	2,609,838.00
Ажилгүйдлийн даатгал	744,028.00	639,627.00
Эрүүл мэндийн даатгал	7,440,300.00	6,396,270.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,476,000.00	21,261,300.00
Байрны түрээс	21,476,000.00	21,261,300.00
Хангамж, бараа материалын зардал	21,912,802.90	18,466,317.00
Бичиг хэрэг	2,244,370.00	1,788,380.00
Тээвэр, шатахуун	16,025,000.00	10,378,500.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,522,002.90	3,425,753.70
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	121,430.00	83,140.00
Аж ахуйн материал худалдан авах зардал		

САГ-2018-/131/СТА-ТШЗ

		2,790,543.30
Нормативт зардал	591,800.00	-
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	591,800.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	3,741,600.00	10,937,000.00
Багаж техник хэрэгсэл		
Хөдөлмөр, хамгааллын хэрэгсэл		
Урсгал засвар	3,741,600.00	10,937,000.00
Томилолт, зочны зардал	19,832,300.00	8,543,470.00
Дотоод албан томилолт	19,832,300.00	8,543,470.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	107,337,493.00	67,773,336.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,735,573.00	62,830,816.00
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,200,000.00	2,178,000.00
Газрын төлбөр	575,000.00	905,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	889,920.00	889,920.00
Тээврийн хэрэгслийн татвар	816,000.00	826,600.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	143,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	187,150,280.31	160,529,731.19
Бараа үйлчилгээний бусад зардал	5,719,759.45	
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,699,860.00	4,883,300.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	176,730,660.86	155,646,431.19
ТАТААС		-
Төрийн өмчит байгууллагад олгох татаас		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,046,134.50	9,218,847.30
Бусад урсгал шилжүүлэг	7,301,484.00	8,400,000.00
Тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн мөнгө	7,301,484.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,400,000.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,744,650.50	818,847.30
Төвлөрүүлэх шилжүүлэг	2,744,650.50	818,847.30
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(166,514,090.31)	214,868,984.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
Үнэ төлбөргүй гарсан зардал		

НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(166,514,090.31)	214,868,984.26
--------------------------------	-------------------------	-----------------------



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	693,094,306.63		(43,760,367.60)	649,333,939.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Тайлант үеийн үр дүн				-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	693,094,306.63	-	(43,760,367.60)	649,333,939.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	693,094,306.63	-	(43,760,367.60)	649,333,939.03
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Тайлант үеийн үр дүн			214,868,984.26	214,868,984.26
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,094,306.63	-	171,108,616.66	864,202,923.29



4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	632,430,032.40	552,341,977.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,524,935.00	931,100.00
Нийтлэг татварын бус орлого	1,524,935.00	931,100.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	1,524,935.00	931,100.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,524,935.00	931,100.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	630,905,097.40	551,410,877.00
Улсын төвлөрсөн төсвөөс	369,555,884.00	414,020,100.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	369,555,884.00	414,020,100.00
Засгийн газрын нөөц хөрөнгийн санхүүжилт		
Нэмэлт санхүүжилтийн орлого	258,920,057.40	128,719,495.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	214,705,238.00	120,669,495.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,228,600.00	8,050,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,986,219.40	
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	2,429,156.00	8,671,282.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,429,156.00	8,671,282.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	624,198,032.40	522,143,977.00
УРСГАЛ ЗАРДАЛ	624,198,032.40	522,143,977.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	605,072,397.90	512,925,129.70
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,929,693.00	323,876,350.00
Үндсэн цалин	354,705,693.00	295,934,550.00
Нэмэгдэл		27,941,800.00
Унаа хоолны хөнгөлөлт	28,224,000.00	
Урамшуулал		
Гэрээт ажлын хөлс		
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,401,084.00	36,219,431.00
Тэтгэврийн даатгал	27,295,471.00	23,351,396.00
Тэтгэмжийн даатгал	3,076,127.00	3,263,800.00
ҮОМШӨ-ний даатгал	3,845,158.00	2,609,838.00
Ажилгүйдлийн даатгал	744,028.00	639,627.00
Эрүүл мэндийн даатгал	7,440,300.00	6,396,270.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,476,000.00	21,261,300.00
Байрны түрээс	21,476,000.00	21,261,300.00
Түлш халаалт		

Цэвэр бохир ус		
Хангамж, бараа материалын зардал	22,628,732.90	16,052,333.70
Бичиг хэрэг	2,660,270.00	1,957,830.00
Тээвэр, шатахуун	16,025,000.00	10,438,500.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,713,372.90	3,425,753.70
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	230,090.00	230,250.00
Нормативт зардал	651,200.00	-
Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	651,200.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	3,741,600.00	11,302,000.00
Багаж техник хэрэгсэл		145,000.00
Хөдөлмөр, хамгааллын хэрэгсэл		
Урсгал засвар	3,741,600.00	11,157,000.00
Томилолт, зочны зардал	19,832,300.00	8,543,470.00
Гадаад албан томилолт		
Дотоод албан томилолт	19,832,300.00	8,543,470.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,186,993.00	89,855,845.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,823,573.00	84,913,325.00
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,200,000.00	2,178,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	651,420.00	889,920.00
Тээврийн хэрэгслийн татвар	816,000.00	826,600.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	143,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		
Газрын төлбөр	575,000.00	905,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,224,795.00	5,814,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,524,935.00	931,100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,699,860.00	4,883,300.00
ТАТААС		
Төрийн өмчит байгууллагад олгох татаас		
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,125,634.50	9,218,847.30
Бусад урсгал шилжүүлэг	7,301,484.00	8,400,000.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж		
Тэтгэвэрт гарахад нэг удаа олгох мөнгөн тэтгэмж	7,301,484.00	
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		8,400,000.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,824,150.50	818,847.30
Төвлөрүүлэх шилжүүлэг	11,824,150.50	818,847.30
Эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын үлдэгдэл буцаасан		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	8,232,000.00	30,198,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	8,232,000.00	30,198,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,232,000.00	30,198,000.00
Дотоод эх үүсвэрээр	30,198,000.00	
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,232,000.00	30,198,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ	(8,232,000.00)	(30,198,000.00)

АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				
УРСГАЛ ЗАРДАЛ	414,520,100.00	413,433,906.70	1,086,193.30	99.74
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,120,100.00	405,033,906.70	1,086,193.30	99.73
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,530,400.00	277,530,400.00	-	100.00
Үндсэн цалин	249,588,600.00	249,588,600.00	-	100.00
Нэмэгдэл			-	
Унаа хоолны хөнгөлөлт	27,941,800.00	27,941,800.00	-	100.00
Урамшуулал			-	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,272,500.00	32,165,101.00	107,399.00	99.67
Тэтгэврийн даатгал	32,272,500.00	32,165,101.00	107,399.00	99.67
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,261,300.00	21,261,300.00	-	100.00
Байрын түрээс	21,261,300.00	21,261,300.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	4,686,400.00	4,684,033.70	2,366.30	99.95
Бичиг хэрэг	518,200.00	337,850.00	180,350.00	65.20
Тээвэр, шатахуун	1,450,200.00	1,110,000.00	340,200.00	76.54
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,514,200.00	3,005,933.70	(491,733.70)	119.56
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	203,800.00	230,250.00	(26,450.00)	112.98
Эд хогшил, урсгал засварын зардал	5,218,000.00	5,218,000.00	-	100.00
Багаж техник хэрэгсэл			-	
Урсгал засвар	5,218,000.00	5,218,000.00	-	100.00
Томилолт, зочны зардал	1,399,900.00	925,470.00	474,430.00	66.11
Дотоод албан томилолт	1,399,900.00	925,470.00	474,430.00	66.11
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	58,868,300.00	58,366,302.00	501,998.00	99.15
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,925,700.00	53,423,592.00	502,108.00	99.07
Аудит баталгаажуулалт	2,178,000.00	2,178,000.00	-	100.00
Даатгалын үйлчилгээ	890,000.00	889,920.00	80.00	99.99
Газрын төлбөр	905,000.00	905,000.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	826,600.00	826,600.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	143,000.00	143,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	4,883,300.00	4,883,300.00	-	100.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	4,883,300.00	4,883,300.00	-	100.00

хийх				
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,400,000.00	8,400,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	8,400,000.00	8,400,000.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,400,000.00	8,400,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	414,520,100.00	413,433,906.70	1,086,193.30	99.74
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	414,520,100.00	413,433,906.70	1,086,193.30	99.74
Улсын төсвөөс санхүүжих	414,520,100.00	413,433,906.70	1,086,193.30	99.74
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих				
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих				

